



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 08 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар Хэрг /1718

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН З.НАРАНТУЯА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, илрүүлэлт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсөвт тусгасан хүүхэд хамгаалал, гэр бүл, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүнгийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 13 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг,
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН З.НАРАНТУЯАГААС
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ
ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

1. УИХ-аар 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн хэргийн нөхцөл байдал, илрүүлэлт, авсан арга хэмжээ, түүний үр дүнд судалгаа хийсэх эсэх, хийсэн бол гарсан үр дүнгийн талаар.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн 2017 оны нөхцөл байдал:

Цагдаагийн байгууллагад дуудлага, мэдээллийн "ESC" болон шаардлагатай бусад програм хангамжийг үе шаттайгаар ашиглалтад оруулснаар 2017 онд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 102 тусгай дугаарт 455,950 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэнээс хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээлэл 31,934, үүнээс 9,697-г гомдол мэдээллийн, 5,655-г гэмт хэрэг, зөрчлийн санд бүртгэж, 16,582 буюу 52,0 хувийг хууль зүйн зөвлөгөө өгсөн, давхардсан, худал дуудлага, гараад зугтсан, хаалгаа тайлж өгөөгүй, эзэнгүй байсан, хаяг нь олдоогүй зэрэг ангиллаар хаасан байна. Тус мэдээллийн санд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нар хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллээс 16,933 буюу 52.8 хувийг хянаж холбогдох алба, нэгж, албан тушаалтанд шилжүүлж бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2017 онд 32,259 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18,7 хувиар өсч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1,286 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 163 хэргээр буюу 11.2 хувиар буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 86,9 хувийг хөнгөн, 6,4 хувийг хүндэвтэр, 5,0 хувийг хүнд, 1,7 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж, 58,8 хувь нь Улаанбаатар хотод, 41,2 хувь нь орон нутагт тус тус бүртгэгдсэн байна. Энэ хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт нийт 1,120 иргэн өртөж хохирсноос хүйсээр нь ангилж үзвэл 1,040 эмэгтэй, 80 эрэгтэй, насаар нь ангилж үзвэл 90 хүүхэд байна. Үүнээс 936 иргэнд хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирч, 9 иргэн нас барж, 640,6 сая төгрөгийн хохирол учирчээ. Хүчирхийлэлд өртөгчдийн дотор 599 эхнэр, 191 хамтран амьдрагч, 52 нөхөр, 39 дагавар хүүхэд, 38 төрсөн хүүхэд, 21 төрсөн эцэг, эх, 10 төрсөн дүү, 7 төрсөн ах, эгч, бусад 163 хүн байна.

Мөн хугацаанд улсын хэмжээнд бүртгэгдсэн бүх гэмт хэрэгт 18,131 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсаны 1,269 буюу 6,9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт шалгагдаж, тэдний 39,1 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн гэж бүртгэгджээ.

Хэлбэрээр нь авч үзвэл давхардсан байдлаар 787 бие махбодын хүчирхийлэл, 309 сэтгэл санааны хүчирхийлэл, 28 бэлгийн хүчирхийлэл, 9 эдийн засгийн хүчирхийлэл, давтамжаар авч үзвэл байнга хүчирхийлэл үйлдсэн 31 тохиолдол бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2017 онд 1,327,017 захиргааны зөрчил бүртгэгдсэний 4,369 буюу 0.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж, өмнөх оны мөн үеэс 1,3 дахин өссөн, зөрчил гаргасан 1,480 хүнд нийт 37,3 сая төгрөгөөр торгох,

2,889 хүнд баривчлах шийтгэлийг Захиргааны хариуцлагын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд зааснаар ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс баривчилсан иргэдийн тоо 3,9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар 2017 онд нийт 5,806 иргэнд аюулын зэргийн үнэлгээ /өндөр 458, дунд 1,818, бага 3,530/ хийгдэж, нийт 4,732 иргэнд хохирогчийн эрх, үүргийг болон хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар мэдэгдэх хуудас хүргүүлж, хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Нэг цэгийн үйлчилгээний төвд нийт 299 иргэн /188 эмэгтэй, 9 эрэгтэй, 102 хүүхэд /-ийг, Түр хамгаалах байранд нийт 210 иргэн /86 эмэгтэй, 2 эрэгтэй, 122 хүүхэд /-ийг, төрөл садан, ойр дотны хүний хамгаалалтад нийт 3,104 иргэн / 2,690 эмэгтэй, 60 эрэгтэй, 354 хүүхэд /-ийг, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст 11 иргэн /1 хүүхэд /-ийг нийт 3,624 иргэнийг хамгаалалтад авсан байна.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн 2018 оны эхний хагас жилийн нөхцөл байдал:

Цагдаагийн байгууллагад 2018 оны эхний 6 сарын байдлаар 275,845 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн 28,371 дуудлага, мэдээлэл бүртгэгдэж, нийт дуудлага, мэдээллийн 10.3 хувийг эзэлж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар үнэлгээ хийх шаардлагатай нийт 1,949 иргэнд аюулын зэргийн үнэлгээ /өндөр 157, дунд 717, бага 1,075/ хийгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн сангаас хохирогчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний төрлийг ангилж үзэхэд нэг цэгийн үйлчилгээний төвд хүргэж өгсөн 148, түр хамгаалах байранд хүргэж өгсөн 54, төрөл садан, ойр дотнын хүний хамгаалалтад хүлээлгэн өгсөн 1,641, асрамж, халамжийн байгууллагад хүргэж өгсөн 40, эмнэлгийн тусламж үзүүлэхээр хүргэж өгсөн 232, нийгмийн ажилтанд мэдэгдсэн 189, хохирогчид тусламжийн хуудас хүлээлгэн өгсөн 190, шаардлагатай хэрэглээний эд зүйл авахад туслалцаа үзүүлсэн 15 тохиолдол бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2018 оны эхний 6 сарын байдлаар 20,042 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 54,5 хувиар өсч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 584 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 137 хэргээр буюу 19,0 хувиар буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 547 буюу 93,7 хувийг хөнгөн, 37 буюу 6,3 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 57,7 хувь нь Улаанбаатар хотод, 42,3 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ.

Энэ хугацаанд нийт гэмт хэрэгт 17,420 иргэн өртөж хохирсноос гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт нийт 373 иргэн өртөж хохирсны 340 буюу 91,1 хувь нь эмэгтэй хүн, үүнээс хохирогчийн насаар ангилж үзвэл 25-39 насны хохирогч дийлэнх буюу 59,2 хувь, 29 буюу 7,8 хувь нь хүүхэд байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж, 296 иргэнд хөнгөн, хүнд гэмтэл учирч, 194,2 сая төгрөгийн хохирол учирчээ.

Мөн хугацаанд улсын хэмжээнд бүртгэгдсэн бүх гэмт хэрэгт 2,443 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсаны 617 буюу 8,6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт шалгагдаж, тэдний 278 буюу 45,0 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн гэж бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд эхний 6 сарын байдлаар 765,471 зөрчил бүртгэгдсэнээс 3,122 буюу 0,4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж, өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурсан, зөрчил гаргасан 25 хүнд 2930.0 мянган төгрөгөөр торгох, 1,925 хүнд баривчлах шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд зааснаар ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс баривчилсан иргэдийн тоо 214 нэгж буюу 12,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд Эрүүгийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо¹

| Он | Гэмт хэргийн тоо | ГБХ-ийн улмаас амь хохирсон хэргийн тоо | | ГБХ-ийн улмаас хүнд гэмтсэн хэргийн тоо | | ГБХ-ийн улмаас хүндэвтэр гэмтсэн хэргийн тоо | | ГБХ-ийн улмаас хөнгөн гэмтсэн хэргийн тоо | |
|-------------|------------------|---|----------------------------|---|----------------------------|--|----------------------------|---|----------------------------|
| | | Нийт | Үүнээс насанд хүрээгүй хүн | Нийт | Үүнээс насанд хүрээгүй хүн | Нийт | Үүнээс насанд хүрээгүй хүн | Нийт | Үүнээс насанд хүрээгүй хүн |
| 2014 | | 11 | 3 | 9 | 1 | 12 | 2 | 44 | 6 |
| 2015 | | 19 | 4 | 10 | 1 | 11 | 0 | 36 | 3 |
| 2016 | | 16 | 4 | 15 | 2 | 29 | 3 | 53 | 8 |
| 2017 | 67 | 19 | 5 | 21 | 3 | 31 | 2 | 405 | 39 |
| Нийт | 67 | 65 | | 55 | | 83 | | 538 | |

Гэр бүлийн хүчирхийлэл, тэр дундаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн гаралт буурахгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлох, түүнийг арилгах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна:

Нэг. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор гүйцэтгэсэн судалгааны ажлууд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Монгол Улс дахь гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, хэтийн төлөв хандлагыг нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай харьцуулан, шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлон төр засаг, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад санал, зөвлөмж болгох зорилгоор анх удаа "Гэмт хэргийн цагаан ном" товхимлыг гаргасан. Уг товхимлын 5 дугаар бүлэгт "Гэр бүлийн хүчирхийлэл ба гэмт явдал", 6 дугаар бүлэгт "Хүүхэд холбогдсон, хохирсон гэмт явдал", 18 дугаар бүлэгт "Бэлгийн мөлжлөг ба хүчиндэх гэмт хэрэг"-ийн талаарх судалгаа тус тус багтсан. Энэхүү судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тодорхойлсон:

- Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гомдол мэдээллийн 70 гаруй хувьд хамаарах тохиолдол нь архидан согтуурсан үедээ үйлдэгдсэн;

¹ Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл

- Гэр бүлийн орчин, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллага, их, дээд сургуульд хүчирхийлэл, гэмт хэргийн талаар үндсэн болон нэмэлт мэдлэг хангалттай олгодоггүйгээс шалтгаалж нийгэм даяараа хүчирхийлэлд дасан зохицох хандлага бий болсон;

- Дээрх нөхцөлд өсч торнисон хүүхдүүд одоо 25-аас дээш насныхан буюу идэр насныханд хамаарч гэр бүлийн харилцаа үүсгэж, эцэг, эх болсон ч нэгэнт хүчирхийллийн зан үйлд дасан зохицсон хүн эрх мэдлийн ялгаатай байдлыг ашиглан гэр бүлийн бусад гишүүнд үзүүлж байгаа дарамт, бие махбодын хүчирхийлэл үйлдэх хэлбэр түгээмэл;

- Гэр бүлийн таагүй уур амьсгал /эцэг, эхийн архидалт, хүүхдэд харгис хэрцгий хандах, хүмүүжлийн буруу арга/, сургуулийн орчин дахь зан суртахууны ба хүйсийн харилцааны алдаа, хувь хүний сэтгэц физиологийн онцлог;

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг сурталчилгаа, цахим орчин дахь хяналтгүй сөрөг мэдээллийн нөлөө.

2. Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт хэрэг, хүүхэд гэмт хэрэгт өртөн хохирч байгаа шалтгаан нөхцөлийг нарийвчлан судлах зорилгоор “Монгол Улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” судалгааг 2013-2017 оны байдлаар хийж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

3. Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт судалгааны хүрээлэнтэй хамтран насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл, шийдвэрлэлт суурь судалгаа, хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгчийн нийтлэг болон онцлог дүр төрхийг тодорхойлох хавсарга судалгаа, гэр бүлийн хүчирхийллийн улмаас бусдыг санаатай алах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, шийдвэрлэлт судалгааг тус тус хийж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж гарсан 34 журмаас Хууль зүй, дотоод хэргийн сайд дангаар 9, Улсын Ерөнхий прокурортой хамтран 1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдтай хамтран 4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 2 журам тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн 108 дугаар утасны үйлчилгээний төв 2017 онд 144,869 дуудлага хүлээн авч, 3,173 тохиолдлыг аймаг, орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /хэлтэс/, Хамтарсан багт шилжүүлснээс 63%-ийг шийдвэрлэсэн байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 84,819 дуудлага хүлээн авч 2,569 тохиолдлыг аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, Хамтарсан багт холбон зуучилж, 936 тохиолдлыг шийдвэрлэж, нийгмийн үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн 327 хүүхдийг шуурхай дуудлагаар хүлээн авч хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байранд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлжээ.

Цагдаагийн байгууллагын дуудлага, мэдээллийн нэгдсэн санд 2018 оноос шинээр гэр бүлийн хүчирхийллийн талаар өргөдөл, гомдол бүртгэх, тайлан боловсруулах тусгайлсан цахим мэдээллийн нэгдсэн санг нэвтрүүлж, дуудлага мэдээллийн дагуу ажиллах цагдаагийн алба хаагчид хүчирхийлэл үйлдэгчийн талаарх мэдээллийг урьдчилан мэдэх, цаашлаад хүчирхийлэл үйлдэгчид ял завших боломж олгохгүй байх, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээг тодорхойлоход ашиглаж байна.

Нийслэлийн цагдаагийн газрын харьяа түр хамгаалах байранд 4 сэтгэл зүйч гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчдод зөвлөгөө өгч, шаардлагатай үйлчилгээг үзүүлж байна.

Улсын хэмжээнд 2018 онд аймаг, дүүргийн цагдаагийн 30 хэлтэст хүүхдээс мэдүүлэг авах өрөөг улсын төсвийн хөрөнгөөр, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийг 7 аймаг, 3 дүүрэгт олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр тус тус байгуулахаар ажиллаж байна.

Үндэсний хэмжээнд 12 аймаг, нийслэлийн Хан-Уул дүүрэг, Баянгол дүүрэгт түр хамгаалах байр ажиллаж, 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар түр хамгаалах байранд 629 хүүхдийг хүлээн авч, үйлчилсэн байна. Үүнээс Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 231 дүгээр тогтоолоор байгуулагдсан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр 0-18 хүртэлх насны 561 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.

Хамгаалах байраар үйлчлүүлсэн хүүхдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд тэдний эцэг, эх, асран хамгаалагч, хамаарал бүхий этгээдийн зүгээс хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг ба 50,6 хувь нь архины хамааралтай, 31,7 хувь нь эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналт сул, 10 хувь нь хүүхдээр хөдөлмөр эрхлүүлж эрхийг нь зөрчиж байна. Түр хамгаалах байрны стандарт, журмыг мөрдүүлэх, хямралын үеийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх орон нутгийн салбарын удирдлага, мэргэжилтнүүдэд зориулсан арга зүйг боловсруулж байна.

2. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгаалах талаар аливаа хэрэг, маргаан гарсны дараа биш урьдчилан сэргийлэх талаар улсын хэмжээнд үүрэг хүлээсэн байгууллагуудын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн үр дүнгийн талаар.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч байна:

- “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе үндэсний аян”-ыг өрнүүлж, 21 аймаг, 9 дүүрэгт 75 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 200 гаруй төрийн байгууллага, төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллага оролцож, нийт 25,000 орчим эцэг эх, 3,500 хүүхдүүд аянд нэгдсэн. Аяны хүрээнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар 855 удаагийн сургалт зохион байгуулж, 1,628 сургагч багш бэлтгэж, боловсролын байгууллагын 8,240 ажилтан, 53,650 эцэг, эхчүүдэд хүүхэд хүмүүжлийн эерэг аргын сургалтыг зохион байгуулж, хүмүүжлийн эерэг аргын талаар зөвлөгөө мэдээлэл, нөлөөлөл сурталчилгааны ажил хийгдэж байна;

- Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүрээнд “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд 40,000 өрхөөс судалгаа авч, 8,100 өрхийг сонгон, гэр бүлийн зөвлөгч нараар дамжуулан тухайн гэр бүлийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг судлан, тодорхойлж, тухайн гэр бүлийн хэрэгцээ, онцлогт тохирсон хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний арга зүйг боловсруулан ажиллахаар төлөвлөж байна. Мөн 21 аймаг, 9 дүүрэгт нийт 3,464 гэр бүлийн зөвлөгч нарыг бэлтгээд байна;

- Бүх яам, агентлаг, төрийн бүх шатны байгууллага, хувийн хэвшлийн байгууллагад “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим” сургалт, нөлөөллийн арга хэмжээг 2018 оны 5 дугаар сараас эхлэн хүүхэд хамгааллын сүлжээтэй хамтран зохион байгуулж, сургалтаар байгууллагын ажилтан, албан хаагчдад “Хүүхдийн эрх, хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн харилцаа, эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж, удирдамж” танилцуулж, “Хүүхэд хамгааллын бодлого” боловсруулж мөрдөх чиглэлээр сургалтыг зохион байгуулж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 11 яам, 8 агентлагт зохион байгуулж, 898 албан хаагч, 21 аймгийн ЗДТГ-т зохион байгуулж, 1,204 албан хаагчийг сургалтад хамруулаад байна. Уг сургалтыг зохион байгуулах 280 албан хаагчийг сургагч багшаар бэлтгэсэн;

- Улсын хэмжээнд гэр бүлд зөвлөгөө өгөх 14 төв, танхим ажиллаж, 2017 онд 34,000 иргэн, гэр бүлд гэр бүлийн үнэ цэнэ, харилцаа, хандлагын талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 2018 оны эхний хагас жилийн байдлаар 21 аймаг, 9 дүүргийн салбар, нэгжүүд “Багшийн ёс зүй, гэр бүлийн харилцаа хандлага”, “Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвээр багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг, эхчүүдэд 170 удаагийн сургалт-лекц зохион байгуулж, 23,750 хүн хамрагдаад байна.

- Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” Зүүн бүсийн зөвлөгөөнийг энэ оны 3 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Дорнод аймагт 3 аймгийн 70 хүн, Үндэсний зөвлөгөөнийг 4 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн салбар нэгжүүдийн 30 хүн, Хангайн бүс Орхон аймагт 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд 6 аймгийн 90 хүний төлөөлөлтэй тус тус зохион байгуулсан;

- Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нас, хүйс, газар зүйн байршил, нийгэм эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр гаргахад дүүрэг, хорооны хэсгийн ахлагч, сум, багийн Засаг дарга, ажилтнуудыг арга зүйгээр хангах, чадавхижуулах “Гэр бүл, хүүхдийн хөгжилд баг, хорооны Засаг дарга, Хэсгийн ахлагчийн үүрэг оролцоо” сургалтыг 2018 оны 5 дугаар сарын 25-аас 6 дугаар сарын 25-ны өдрийн хооронд 21 аймаг, 8 дүүрэгт амжилттай зохион байгуулж, 21 аймгийн 1,613 багийн Засаг дарга, сумын холбогдох мэргэжилтэн, 9 дүүргийн хорооны 1,504 хэсгийн ахлагч, дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас нийт 3,338 хүн хамрагдсан;

- Хүүхэд, өсвөр үеийнхнийг дэлгэцийн донтолт, цахим орчны гэмт хэрэг, хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн техник, технологийн зохистой хэрэглээг дэмжиж ажиллах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран *“Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох, цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх”* чиглэлээр авах арга хэмжээний төлөвлөгөөг хамтран баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 410 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам” болон “Интернэт кафе, цахим тоглоомын үйлчилгээний байранд тавигдах шаардлага MNS 6430:2014 стандарт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах талаар холбогдох байгууллагууд хамтран ажиллаж байна.

- Цахим орчны хүүхдэд сөрөг нөлөөтэй онлайн контентийг тодорхойлох, насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээ хийх тогтолцоог боловсронгуй болгох, хүүхдэд сөрөг нөлөөтэй контентийг тодорхойлох, холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах;

- Хэрэглэгчийн шүүлтүүрийн програмыг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, эцэг, эхийн хяналттай, садар самуун хүүхдэд сөрөг нөлөөтэй вебсайтуудыг хаасан, хязгаарласан програм хангамжийг хөгжүүлэх судалгаа хийх;

- Цахим орчны хүүхэд хамгаалал, өсвөр үе, хүүхэд, залуучуудын дунд онлайн орчны ёс зүйтэй хэрэглээг хэвшүүлэх хүрээнд үүрэн холбооны хэрэглэгч, түүний дотор хүүхдийн эзэмшиж, ашиглаж байгаа дугаарыг бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Ингэснээр насанд хүрээгүй хүнийг гар утасны дата ашиглан залилах, доромжлох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

- Зам тээврийн осол, гэмтэл 0-5 хүртэлх насны хүүхдийн 3 дахь, 6-18 насны хүүхдийн 2 дахь гол эрсдэлт шалтгаан болж байна. Зам тээврийн осол гэмтэлд өртөж байгаа хүүхдийн тоог бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхдэд зориулагдсан автомашины суудлыг гаалийн татвараас чөлөөлөх, зах зээлд худалдаалагдаж байгаа үнийг бууруулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, суудлын зориулалттай автомашин хэрэглэгчдийн /392,0 мянга/ 30 хүртэлх хувьд хэрэглүүлж хэвшүүлэхээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

- ХНХЯ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “Зам хөндлөн гарахдаа заавал хэвшүүлэх дүрэм” 54 секундийн видео шторк, 2018 оны ширээний хуанли 4000 ширхэг, Хүүхдийн хамгаалалтын суудлын ач холбогдол, суудлын зориулалттай автомашин хэрэглэгчдэд хэрэглэж хэвших постерийг боловсруулж, олон нийтийн сүлжээгээр түгээх, сургалтад ашиглах, сургууль, цэцэрлэг, алслагдсан гэр хороололд очиж сургалт зохион байгуулах ажлыг хамтран зохион байгуулж байна;

- “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагатай хамтран автомашины арын цонхонд наах хүүхдийн зориулалттай суудлыг хэрэглэж хэвшихийг уриалсан стикер наалт боловсруулан 30,000 ширхэгийг хэвлэн Цагдаагийн ерөнхий газар, 60,000 ширхэгийг хэвлэн, аймаг, орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэст хүлээлгэн өгсөн;

- “Хүүхдээ хамгаалъя” хүүхдийн зориулалттай автомашины суудлыг 4,000 ширхэгийг захиалан хэрэглэгчдэд нийлүүлэхээр ажиллаж байна;

- Хүүхдийн тусламжийн 108 дугаар утасны үйлчилгээний төвд ирсэн сургуулийн орчин дахь үе тэнгийнхний дарамт, хүчирхийлэл, орчны аюулгүй байдал хангалтгүй, багш, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс хүүхэдтэй зүй бус харилцсан зэрэг дуудлагад дүн шинжилгээ хийж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд 2018 онд боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудалд анхаарал хандуулан хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, багш, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн “Хүүхэд хамгааллын жишиг сургууль” туршилтын төслийг шалгуур үзүүлэлтийн дагуу сонгож, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 31 сургууль дээр хэрэгжүүлж байна. Төслийн хэрэгжилтийн хүрээнд хүүхэд бүрт хүрсэн хөгжлийн хөтөлбөртэй, хүүхэд бүрийн оролцоог хангасан дугуйлан секцтэй, сургуулийн дотоод, гадаад орчны эрүүл, аюулгүй байдал сайжирч, сургууль бүр “Хүүхэд хамгааллын бодлого”-той болох юм. Тус төслийн

сайн туршлагыг 2019 онд үндэсний хэмжээний Ерөнхий боловсролын сургууль /798 сургууль/-д түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна;

- НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Хөвсгөл аймаг, Налайх дүүрэгт хэрэгжүүлсэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” орон нутгийн хүүхдэд ээлтэй засаглалыг бэхжүүлэх хөтөлбөрийн туршлага, үр дүнд суурилж, Говь-Алтай, Баянхонгор, Завхан аймаг, нийслэлийн Баянзүрх дүүрэгт уг хөтөлбөр хэрэгжиж байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтын хөтөлбөрийн арга зүйд тулгуурлан Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Увс аймгуудыг сонгон “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж байгаа ба холбогдох зардлыг аймаг, орон нутгийн төсөв, хүүхэд хамгааллын зардлаас санхүүжүүлэхээр төлөвлөж байна;

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлж ашиглах журам”-ын дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар “Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн нэгдсэн сан”-г бүрдүүлэн ашиглаж эхэлсэн. Тус санд 2018 оны эхний хагас жилд хурдан морь унаач хүүхдийн, халамж, асрамжийн төвд амьдарч байгаа хүүхэд, хараа хяналтгүй хүүхдийн мэдээллийг оруулж, санг баяжуулсан. Эдгээр хүүхдийг хурууны хээгээр бүртгэх ажил эхэлж байгаа бөгөөд бүртгэлийг хийснээр тухайн хүүхдийн шилжилт хөдөлгөөнийг хянах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа эсэх, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах боломж бүрдэх юм;

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Монгол Улсын хэмжээнд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шийдвэрлэлтийг сайжруулах, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээний загвар, аргачлалыг бий болгох чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хэрэгцээ, шаардлагад үндэслэн 2017 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, хэрэг шийдвэрлэлтийн байдалд “Хөгжлийн Академи” ТББ-аар “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх нь” судалгаа /2014-2017 оны хавтаст хэрэг/-г хийлгэсэн байна. “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд үзүүлэх стратегийн өмгөөлөл” хийх ажлыг “Хөгжлийн академи” ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж байна;

- Хүүхдийн хөдөлмөр, хүчирхийллийн асуудлаар хийх Судалгааны удирдах хороог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/136 дугаар тушаалаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, судалгааг 2018 онд багтаан хийж, гүйцэтгэхээр ажиллаж байна;

- Хохирогчийг хамгаалах байрны судалгаа: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2017 онд хийж, орон нутагт үзүүлж байгаа хамгаалах байрны талаар тодорхой мэдээлэлтэй болсон. Энэхүү судалгааг НҮБ-ын Хүн амын сангийн Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд өргөжүүлж чанарын судалгаа хийж, байрны нөхцөл байдал, хүргэж байгаа үйлчилгээний талаар судалгаа хийсэн. Уг төслийн хүрээнд 12 аймаг, 5 дүүрэгт хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрыг хамтран байгуулах хөрөнгө оруулалтууд хийгдэнэ;

- Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа: НҮБХАС, Үндэсний статистикийн хорооноос жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааг 2017 онд улс даяар явуулж, судалгааны дүнг Үндэсний статистикийн хороо энэ оны 6 дугаар сарын 14-нд олон нийтэд танилцуулсан. Энэхүү судалгаа нь Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийллийн талаар хийсэн анхны томоохон хэмжээний тоон болон чанарын судалгаа болсон. Хүчирхийллийн судалгаанд эмэгтэйчүүдийн эсрэг бие махбодын, бэлгийн, эдийн засгийн, сэтгэл санааны, хянах зан үйлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг бүрэн хамарч судалсан. Судалгаанд хот хөдөөгийн 7300 гаруй эмэгтэйчүүдийг хамруулж, ойр дотны болон бусдын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийн түвшинг хэт өндөр байна гэж тогтоосон байна. Судалгааны гол үр дүнгээс танилцуулахад судалгаанд хамрагдсан хамтрагчтай эмэгтэйчүүдийн 57.9 % нь аль нэг хэлбэрийн болон хэд хэдэн хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байна. Мөн тэдний 31.2% нь бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Хамтрагч бус бусдын үйлдсэн хүчирхийлэлд 15-аас дээш насны эмэгтэйчүүдийн 17.3 хувь нь өртсөн байна. Судалгаагаар 10 эмэгтэй тутмын нэг нь бусдын үйлдсэн хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлд 15 нас хүрэхээсээ өмнө өртсөн гэсэн дүгнэлт гарсан байна. Энэхүү судалгааны дүнг нарийвчлан судалж, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гарч байгаа шалтгааныг тодорхойлж, цаашид авах арга хэмжээ, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааг тодорхойлон ажиллана;

- БНХАУ-ын Эрээн хот, Хайлаар, Манжуур, Дүрэмт хошуунд амьдарч байгаа иргэд, гэр бүл, хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийх ажлыг 2018 оны 9-10 дугаар сард зохион байгуулахаар Гадаад харилцааны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар зэрэг байгууллагууд хамтран ажиллаж байна;

- Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхдийн асуудлаарх мэдээллийн сан бий болгох, хүүхдийн эрхийн улсын байцаагч, нийгмийн ажилтны ёс зүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийг магадлан итгэмжлэхтэй холбоотой 10 дүрэм, журам, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хохирогчид үзүүлэх түр хамгаалан байрлуулах, нийгмийн халамжийн, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах асуудлын зохицуулалтыг тусгасан нийт 12 дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлж байна;

- Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг /2017-2021 он/ Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор, хөтөлбөрийг 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд бүх яам, агентлаг, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдаар ахлуулсан "Хүүхдийн хөгжил, хамгааллын байнгын ажлын хэсэг" байгуулагдан ажиллаж байна;

- Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн хурлыг 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 02 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар холбогдох яам, агентлагуудад үүрэг, чиглэлийг Ерөнхий сайдаас өгсөн. Мөн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөг батлуулан, Үндэсний зөвлөлийн

тогтоол, хурлын тэмдэглэлийг гишүүд болон орон нутгийн хүүхдийн зөвлөлийн тэргүүн нарт хэрэгжилтийг хангуулахаар хүргүүлээд байна;

- Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанд хүүхдийн эрх, аюулгүй байдалтай холбоотой асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд мэдээлэл хийж, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг иргэд, олон нийт, байгууллага, аж ахуйн нэгжид зохион байгуулах, бүх түвшинд хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг мөрдүүлэх, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр /2017-2021/-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэхээр Засгийн газрын гишүүд, холбогдох агентлаг, бүх шатны Засаг дарга, Улсын баяр наадмыг зохион байгуулах комисс, бүх шатны төрийн байгууллагад үүрэг чиглэл өгч, үүрэг, бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, Монголын морин спорт уяачдын холбоо, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагад уриалга гаргаж, албан даалгаврын хэрэгжилтийг улирал бүрээр дүгнэж, тайлангаа ирүүлэхийг даалгасан.

3. Хүүхдийн эрхийн хамгаалалт муу, аюулгүй орчинг бүрдүүлэх талаар иргэд, байгууллагын хариуцлага туйлын сул байгаа нь гэмт хэрэг гарах нэг үндэс нөхцөлийг бүрдүүлж байгаа талаар нийгэмд, цахим ертөнцөд ихээр мэдээлэгдэж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага болон анхан шатны байгууллага болох хороо, нийгмийн ажилтнууд, цагдаа гэх мэт байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа маш муу байна. Энэ нөхцөл байдлыг сайжруулахаар гаргасан ажлын төлөвлөгөө, хэрэгжүүлж буй тусгай хөтөлбөр байна уу? Байгаа бол дэлгэрэнгүй танилцуулна уу.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/27 дугаар тушаалаар Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн доор Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийг байгуулан ажиллаж байна.

Дэд зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг хангах зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” Үндэсний чуулганыг 2017, 2018 онд зохион байгуулсан. 2018 оны чуулганд Нийслэл, 21 аймаг, 9 дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга нар, эрүүл мэндийн газрын дарга нар, боловсрол, урлагийн газрын дарга нар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга нар, цагдаагийн алба хаагч нар нийт 200 хүн оролцсон бөгөөд мөн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” бүсийн зөвлөгөөнийг Дорнод, Орхон аймагт зохион байгуулж, чуулган зөвлөгөөний үеэр хуулиар үүрэг хүлээсэн 350 гаруй албан хаагчдыг сургалтад хамруулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран 2017 оныг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хуулийн дагуу үүрэг хүлээсэн албан хаагчдыг чадваржуулах жил болгон зарлаж, “Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалт”-ыг зохион байгуулж, 609 Хамтарсан багийн 4,634 гишүүдийг чадавхижуулах, тэдгээрт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий “Хамтарсан багийн туршлага судлах сургалт, уулзалт”-ыг 2018 оны 6 дугаар сарын 04-26-ны өдрүүдэд зохион байгуулж, Улаанбаатар хотод 8 аймгийн Хамтарсан багийн 154 гишүүн, Нийслэлийн хороодын Хамтарсан багийн 220 гишүүн хоорондоо, Төв аймагт 6 аймаг, 1 дүүргийн Хамтарсан багийн 161 гишүүнийг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгснөөс гадна сайн туршлага бүхий Хамтарсан багийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлах ажлыг зохион байгуулсан.

Мөн “Гэр бүл, хүүхдийн хөгжилд баг, сум, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтны үүрэг оролцоо” сургалтыг 21 аймаг, 8 дүүргийн хэмжээнд зохион байгуулж 3,338 хүнийг хамруулсан. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх сургалтыг зохион байгуулж, одоогийн байдлаар 10 аймгийн 500 орчим цагдаа, шүүх, прокурорын байгууллагын ажилтан, өмгөөлөгчдийг хамруулаад байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсооход олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газартай хамтран “Хайрла-Хамгаал” үндэсний цахим аяныг улсын хэмжээнд зохион байгуулсан. Мөн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор телевизийн болон радиогийн нэвтрүүлэг, богино хэмжээний видео сурталчилгаа, зурагт хуудас бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэх ажлыг тасралтгүй зохион байгуулж байна.

Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 дугаар утасны үйлчилгээний төв”-ийг байгуулсан ба уг төвд сард дунджаар 10 мянга гаруй дуудлага, хандалт ирж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/292 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу тус төвийн тээврийн хэрэгсэлд тусгай болон гэрлэн дохио хэрэглэж байгаа нь хүүхдэд хүүхэд хамгааллын яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжийг нэмэгдүүлсэн.

Нийслэлийн цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас эцэг, эхийн хараа хяналт сул хүүхдийг илрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хүүхдүүдийг эцэг эх асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх, шаардлагатай тохиолдолд хамгаалах байр, халамж, асрамжийн төвүүдэд байршуулж, удаан хугацаагаар тэнэсэн гэр бүлдээ очих боломжгүй хүүхдүүдийг Багахангай дүүрэгт байгуулсан “Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх төв”-д байрлуулан нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж байна. Одоогоор тус төвд 17 хүүхэд байнга байрлаж, үйлчилгээ авч байна.

Түүнчлэн хүүхдийн эрх, хамгааллын болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хуульд заасан үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх хууль, тогтоомжийг олон нийтэд таниулан сурталчлах, ойлголт хандлагыг нэмэгдүүлэх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, Зөрчлийн тухай хуульд заасан хүүхдийн эсрэг 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүрэгтэй ажиллах хүүхдийн эрхийн байцаагчийг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.3 дахь хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулж, сургалтанд хамруулан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/181 тоот тушаалаар 32 албан хаагчид Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгосон. 2017 онд 26, 2018 оны эхний хагас жилд

87 зөрчлийг илрүүлснээс 55 хэргийг шийдвэрлэж, 19 хэргийг шалгаж байгаа бөгөөд 13 хэргийн холбогдогчид нийт 1.950,000 төгрөгийн торгуулийн шийтгэл, оногдуулсан байна;

- Хүүхдийн эрхийн улсын байцаагч нарын 2018 оны хяналт, шалгалтын төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/84 дүгээр тушаалаар батлан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын дагуу хяналт, шалгалт хийх, сүм хийд, дотуур байр, интернэт тоглоомын газруудад төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж, зөвлөн туслах, зөрчлийг илрүүлэх, шалгах, хууль сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулан, ажиллаж байна;

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Хамтарсан багаас 2017 онд 1,298, 2018 оны 2 дугаар улирлын байдлаар 1,548 гэр бүлийн хүчирхийлэлтэй гэр бүлтэй ажиллаж, 2,336 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор 6,318 хүүхэд, иргэнд аюулгүй байдлын хамгаалалт, сэтгэл зүйн зөвлөгөө, эмнэлгийн тусламж, холбон зуучлах үйлчилгээг үзүүлсэн;

- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журмын дагуу аймаг, дүүрэгт хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй салбар дундын "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо" байгуулагдан ажиллаж, 2017 онд 618 хүүхдэд, 2018 оны 2 дугаар улирлын байдлаар 897 хүүхдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн;

- Нийслэлийн хороодын Хэсгийн ахлагч нарын ажил үүргийн хуваарьт хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг оруулж, бүх Хэсгийн ахлагч нарыг сургалтад хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан "Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт"-ыг 2017 оны 12 дугаар сард Стандартчиллын үндэсний зөвлөлөөр батлуулж, шинэчлэгдсэн стандартыг халамж, асрамжийн төвүүдэд мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2018 оны 6 сарын байдлаар Монгол Улсад 31 асрамж, халамжийн төв ажиллаж байгаагаас 3 төв нь буюу Өнөр бүл хүүхдийн төв, Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор, Нялхасын клиник сувилал улсын төсвөөс, 28 төв нь олон улсын болон гадаадын иргэний санхүүжилтээр ажиллаж байна.

2018 оны 6 дугаар сарын байдлаар дээрх төвүүдэд 1,013 /529 эрэгтэй, 484 эмэгтэй хүүхэд/ байна. Улсын төсвөөс санхүүждэг Өнөр бүл хүүхдийн төвд 189, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт 129, Нялхасын клиник сувилалд 33 хүүхэд, хувийн халамж, асрамжийн 28 төвд 662 хүүхэд амьдарч байна. 2018 онд халамж, асрамжийн төвөөс 18 нас хүрч, нийгэмд бие даан амьдрах 55 хүүхэд байна. Мөн 18-аас дээш насны 21 залуус амьдарч байна. Асрамж, халамжийн төвд амьдарч байгаа хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулах, мэдээллийн санг бүрдүүлэх, тэтгэмжээ авч чадахгүй байгаа хүүхдийн асуудлыг шийдвэрлэх, хагас өнчин, эцэг, эх нь асран хамгаалагчийн үүргээсээ татгалзсан, асрамж халамжийн төвд амьдрах хугацаанд эцэг, эх нь сураггүй болсон хүүхэд, залуусыг бүтэн өнчинд тооцож, нийгмийн

халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох асуудлыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.

Хурдан морины унаач хүүхдийн бүртгэлийн маягтыг шинэчлэн боловсруулж, хурдан морины унаач хүүхдийг цахим бүртгэлээр бүртгэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулахаар ажиллаж байна. Стандарт, хэмжил зүйн газраас “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” MNS 6264:2011 стандартыг 2018 оны 5 дугаар сард шинэчлэн баталсан. Түүнчлэн хурдан морины унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалын нөхцөлийг сайжруулж, даатгалын хураамжийг 100,000 төгрөг болгож, нөхөн олговрыг нэмэгдүүлэх асуудлаар Санхүүгийн зохицуулах хороо, даатгалын компаниудтай хамтран ажиллаж байна.

4. Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсөвт хүүхэд хамгаалал, гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан 5 тэрбум төгрөгийн зарцуулалт, түүний үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлнэ үү.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны төсөвт хүүхэд хөгжил, хамгааллын хөтөлбөрт 5.8 тэрбум төгрөг батлагдсанаас энэ оны 5 дугаар сарын байдлаар 2.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Батлагдсан төсвийн хуваарилалтыг бүс нутгийн онцлог, хүүхэд, гэр бүл, залуучуудын тоотой уялдуулан хийсэн ба өмнөх онтой харьцуулахад орон нутагт олгож буй санхүүгийн дэмжлэг 11.9 дахин нэмэгдсэн. Үүнд:

- Хүүхэд, гэр бүлийн бодлого төлөвлөлт, зохицуулалтад салбар дундын хамтын ажиллагааг сайжруулахад - 9.9%;

- Хүүхэд, гэр бүлийн чиглэлээрх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулахад- 12,6%;

- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний төвүүдийг бэхжүүлэх, хамгааллын үйлчилгээнд *Юлон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Өнөр бүл, хүүхдийн төв, ХТУ-108, Хариу үйлчилгээний түр хамгаалах байр, Сургалт, судалгааны мэдээллийн төв, “Нарт хангай хараа хяналтгүй хүүхдийн хөгжлийн төв*- 13.7%;

- Олон нийтийн ойлголт, хандлагыг дээшлүүлэх нөлөөлөл, сурталчилгаанд- 3.3%;

- Хөгжил, хамгааллын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай гэрээ, санамж бичгийн хүрээнд зарцуулсан зардалд- 23.9%;

- Орон нутаг, нийслэл, дүүргийн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд- 36,5%.

Одоогийн байдлаар нийт 2.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 61.0%-ийг урьдчилан сэргийлэх, чадваржуулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд, 39.0%-ийг хамгааллын үйлчилгээнд зарцуулж байна.

—oOo—